

Засгийн газраас баталсан “Малын чанар сайжруулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

2009 оны эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл							
	Хөтөлбөрийг баталсан Засгийн газрын тогтоолын дугаар, огноо		2006 оны 4-р сарын 26-ны 93-р тогтоол							
1.	Хөтөлбөрийн зорилго		Хөтөлбөрийн эрхэм зорилго нь мэргэжлийн албадын чадавхийг бэхжүүлэх замаар малын чанарыг сайжруулах, удмын санг хамгаалах, мал үржлийн ажилд дэвшилт арга, технологи нэвтрүүлэхэд оршино.							
2.	Хөтөлбөрийн зорилтууд /үе шатны хугацаатай нь авч үзэх/	Эхний үе шат 2006-2008 он	1. Цөм сүргийг баталгаажуулан бүртгэлжүүлж, үржил, ашиг шимийн мэдээллийн сан, тогтолцоо бий болгоно.							
		Хоёр дахь үе шат 2008-2012 он	2. Малын удмын сангийн нөөцийг баяжуулна.							
		Гуравдахь үе шат 2012-2015 он	3. Малын чанар, ашиг шимийг дээшлүүлэх, малчин өрхийн аж ахуйг эрсдэлээс хамгаалах эдийн засаг, эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.							
			4. Мал үржлийн ажил, үйлчилгээ эрхлэх иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн чадавхийг дээшлүүлж, үр дүнг сайжруулна.							
3.	Зарцуулсан хөрөнгө	Төсөв /шаардагдах нийт зардал/	I үе шат буюу 2008 он хүртэлх хугацаанд 8.806.500.000 төгрөг зарцуулна. Үүнээс 2.558.500.000 төгрөгийг улсын төсвөөс гаргахаар төлөвлөсөн.							
		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/, үүнээс	470.34 сая төгрөг							
		Тухайн жилд зарцуулсан	279.4 сая төгрөг							
4.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлтийн хувь	Дүн	100	90	70	50	30	10	0
		Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын тоо	4		1	1	2			
5.	Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл		Төлөвлөсөн	Гүйцэтгэл					Хувь	
	Шалгуур үзүүлэлт тус бүрээр	1. Бүртгэлд авсан үүлдэр, цөм сүргийн тоо /мян.тол/	1000 мян.тол-д хүргэх	2007 онд 748,33 мян.тол байсан бол 2008 онд 967.4 мян.тол, 2009 онд 963.8 мян.тол байна.					96.4 %	
		2. Баталгаажсан хээлтүүлэгч /хувиар/	90.0 %-д хүргэнэ.	Үзлэгт хамрагдсан хээлтүүлэгчийн 92,2 % нь тэнцсэн байна.					100 %	
		3. Бүртгэл мэдээллийн сан, сүлжээнд хамрагдсан нэгжийн тоо	22 нэгжид мэдээллийн сан бүрдүүлж эхлэх.	Аймгуудын мал үржлийн албадын мэргэжилтнүүдийг мэдээллийн сан бүрдүүлэх чиглэлээр сургаж дадлагажуулсны зэрэгцээ					100 %	

			компьютер, түүний дагалдах хэрэгсэрээр хангасан. Ингэснээр мэдээллийн сан бүрдүүлэх ажил хэрэгжих нөхцөл хангагдсан бөгөөд мэдээллийн сан бүрдүүлж эхэлсэн байна.	
	4. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо	Бууранд 21, Азарганд 8, Буханд 26, Хуцанд 45, Ухнанд 45 хээл-тэгч ноогдох.	Бууранд 25, Азарганд 7, Буханд 28, Хуцанд 64, Ухнанд 66 хээлтэгч ноогдож байна. Энэ нь азарганаас бусад хээлтүүлэгчийн хувьд 2005 оны суурь үзүүлэлтээс буурсан, 2009 онд төлөвлөсөн түвшиндээ хүрээгүй болохыг нотлон харуулж байна.	20.0 %
	5. Мал үржлийн ажил, үйлчилгээ эрхэлж байгаа эрх бүхий ААН, иргэн, Үржлийн төвийн тоо	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тоог 100-д хүргэнэ.	Энэ үзүүлэлт 50 болж өмнөх жилийнхээс 7-оор буурсан.	0 %
		Үржлийн төв 6-г байгуулна.	Нийт 12 Цөм сүргийн үржлийн төвийг шинэчлэн зохион байгуулсан.	100 %
	6. Үржилд зориулан бойжуулсан малын тоо /мян.тол/	Хээлтүүлэгчийн тоог 175.2 мян.тол-д хүргэнэ.	46.4 мянган толгой хээлтүүлэгчийг үржилд зориулан божуулсан нь зорилтот түвшинтэй харьцуулахад нэн хангалтгүй байна.	26.5 %
		Хээлтэгчийн тоог 306.3 мян.тол-д хүргэнэ.	784.0 мянган толгой хээлтэгчийг үржилд зориулан бойжуулжээ.	100 %
	7. Үйлдвэрлэсэн үржлийн бүтээгдэхүүний тоо	Үр үйлдвэрлэлийг 20000-д хүргэнэ.	6000	30.0 %
		Хөврөл үр үйлдвэрлэлийг 200-д хүргэнэ.	353	100 %
	8. Гадаадаас авсан мал, үр, хөврөл үрийн тоо	3000-аас доошгүй тооны өндөр ашиг шимт мал импортлоно.	400 толгой мал импортлосон.	13.3 %
		500-аас доошгүй тооны амьтан импортлоно.	30000	100 %
		Үр, хөврөл үрийн	Үр, хөврөл үр 25.000-г импортлосон.	100 %

			импор-тыг 20000-д хүргэнэ.		
		9. Нийт малд цэвэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн малын эзлэх хувь	9.0 %-д хүргэнэ.	2009 оны жилийн эцсийн тооллогын дүнгээс үзвэл 7.3 %-г эзэлж байна.	61.1 %
		Гүйцэтгэлийн дундаж хувь			67.7 %
6.	Хөтөлбөрийн гол үйл ажиллагаа, гарц	<p>- “Малын үржлийн ажлын стратеги төлөвлөгөө” “Бод малыг индексжүүлсэн тамга, дугаарын сүлжээнд хамруулах тухай” журам, Цөм сүргийн үржлийн аж ахуй байгуулах тухай ТӨХ-ны тогтоол зэргийг боловсруулан баталгаажуулсны зэрэгцээ ”Монгол мал” үндэсний хөтөлбөрийг боловсруулсан.</p> <p>- Цөм сүргийн үржлийн малд хөтлөх үржлийн гэрчилгээг 5 төрлийн малаар шинэчлэн боловсруулж 90 мянган ширхэгийг хэвлүүлэн аймгийн Мал үржлийн албадад хүргүүлж цөм сүргийн малыг бүртгэлжүүлэх ашиг шим, удам гарвалын гэрчилгээтэй болгох ажлыг зохион байгуулсан.</p> <p>- Мал сүрэгт үзлэг ангилалт хийх ажлын явц, анхаарах зарим асуудал, санхүүгийн баримт бүрдүүлэлт зэрэг асуудлаар зохион байгуулсан бүсчилсэн сургалтад 120 гаруй мэргэжилтэн, Малыг шилэх, тохируулан сонгох, үр төлийн чанараар нь үнэлэх мэргэшсэн шинжээч мэргэжилтэн бэлтгэх сургалтад 38 хүн, бог, бод малын зохиомол хээлтүүлгийн технологич бэлтгэх 2 удаагийн сургалтад 40 гаруй хүн, мал ээмэгжүүлэх бүртгэлжүүлэх чиглэлийн 4 удаагийн сургалтад 130 мэргэжилтэн хамрагдсан.</p> <p>- 2008-2009 онд Чехийн засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Төвийн бүсийн аймаг, сумдын малыг ээмэгжүүлэх” төслийн хүрээнд 12 аймгийн цөм сүргийн аж ахуйн 25,0 мянган мал, төвийн бүсийн 6 аймгийн 70,0 гаруй мянган хээлтүүлэгчийг ээмэгжүүлэн бүртгэлжүүлсэн.</p> <p>- Дэлхийн ХХААБ-ийн шугамаар хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд хар тарлан үүлдрийн 5000 тун үрийг импортлон төвийн бүсийн аймгуудын саалийн чиглэлийн үхэр үржүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үнээнд хээлтүүлэг хийх үйлчилгээ хүргэж байна.</p> <p>- МААЭШ-ний хүрээлэнгийн “Махны хонь” төсөлтэй хамтран Алтанбулаг, Суффольк үүлдрийн 28 хониноос 353 хөврөл үйлдвэрлэсний зэрэгцээ Алтанбулаг, Баяд, Орхон, Хангай, Суффольк зэрэг 9 хуцнаас 4500 тун үр үйлдвэрлэн генийн санд авсан.</p> <p>- Цөм сүргийн үржлийн аж ахуйн үйл ажиллагааны чадавхийг сайжруулах болон үржлийн мал бойжуулж борлуулах, үржүүлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр аймаг орон нутгаас боловсруулж ирүүлсэн төслийг сонгон шалгаруулж шаардлага хангасан нийт 18 төсөлд ХХААХҮ-н сайдын 2009 оны 173 дугаар тушаалаар 121 сая</p>			

		төгрөгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлүүлж төсөл нь шалгарсан аж ахуйн нэгжтэй бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулан санхүүжилтийг олгов.
7.	Дүгнэлт /хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр ашиг, үр өгөөж/	<p>- 2009 онд нийт 4833,1 мянган малд үзлэг ангилалт хийж 35,2 мянган хээлтүүлэгч шинээр нөхөн тавьж 996,6 мянган малыг цөм сүргийн малыг бүртгэлд авсан байна.</p> <p>- Хөтөлбөрийн үр дүнг дээр дурьдсан 14 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 1 үзүүлэлт огт биелээгүй, 3 үзүүлэлт хангалтгүй биелэлттэй байна.</p> <p>- 2009 онд цөм сүргийг баталгаажуулан бүртгэлжүүлж, үржил ашиг шимийн мэдээллийн сан, сүлжээ бий болгох асуудлыг тоног төхөөрөмжийн хүрээнд анхаарч нэлээд хэмжээний хөрөнгө зарцуулсан хэдий ч мэдээллийн бааз үүсгэх, сүлжээнд холбох талаар 2009 онд мөн ахиц гараагүй байна.</p> <p>- Үржлийн малын үзэсгэлэн, үнэ хаялцуулах худалдаа зохион байгуулах ажил хөтөлбөр батлагдахаас өмнө хэрэгжиж эхэлсэн хэдий ч зохион байгуулалт, хамрах хүрээний хувьд хөтөлбөрийн дэмжлэгээр илүү сайжирч байна.</p>
8.	Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс, гарсан гажуудал	<p>- Гадаадаас өндөр ашиг шимт мал импортлон оруулж ирэх, дотооддоо үр, үржлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилт хангалтгүй хэрэгжиж байна.</p> <p>- Орон нутгийн нэгжүүдийг нэгдсэн сүлжээнд холбож бүртгэл, мэдээллийн сан үүсгэх ажил хэрэгжээгүй байна. Увс, Орхон, Хэнтий аймгууд дахь Цөм сүргийн үржлийн төв, ХХААГ-н ажилтай танилцаж байхад мэдээллийн бааз үүсгэх, компьютер техник хэрэгслийг ашиглах чадвар ихээхэн доогуур байгаа нь харагдаж байв.</p>
9.	Эдгээрээс гарах арга зам	<p>- Гадаадаас өндөр ашиг шимт мал импортлон оруулж ирэх үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтыг оновчтой болгон цаашид тогтвортой үргэлжлэх бололцоог хангаж өгөх.</p> <p>- Цөм сүргийн мал, үр, үржлийн бүтээгдэхүүн дотооддоо үйлдвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн удирдлага, мэргэжилтний зах зээлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэн аж ахуйн үйл ажиллагаагаа эрчимжүүлэхэд нь мэргэжлийн туслалцаа үзүүлэх.</p>
10	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаарх үнэлгээ	<p>- Хөтөлбөрт тусгагдсан зарим ажлыг ТББ-уудтай хамтран гүйцэтгэхээр тусгасан хэдий ч тодорхой үр дүнтэй ажил зохион байгуулаагүй байна. Иймээс ТББ-ын оролцоо хангалтгүй байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.</p> <p>- Гадаад орон, олон улсын байгууллагын дэмжлэгийг авах талаар анхаарч ажиллан зохих үр дүнд хүрчээ. Тухайлбал, Ядуурлын бууруулах хөтөлбөрийн газар, Чех Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлж байгаа “Төвийн бүсийн малыг ээмэгжүүлэх төсөл”, ЕХ-оос хэрэгжүүлж байгаа “Малын эрүүл мэнд-Мал аж ахуйн зах зээл төсөл” Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас хэрэгжүүлж байгаа “Үржлийн ажлыг сэргээн сайжруулах” төслүүдтэй малын чанар сайжруулах,</p>

		мэргэжлийн үйлчилгээний нэгжийн чадавхийг сайжруулах, мал бүртгэлжүүлэх чиглэлээр хамтран ажиллажээ.
11	Хөтөлбөрийн талаарх яамны санал /өөрчлөн сайжруулах болон бодлогод үзүүлж буй хөтөлбөрийн дэмжлэгийг нэмэгдүүлэх талаар гэх мэт/	Хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны үнэлгээний дүнг 2010 онд ХХААХҮ-ын СЗ-ын хуралдаанд танилцуулахаар төлөвлөсөн. Хөтөлбөрийг ерөнхий төлөвлөгөөний дагуу цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг дэмжиж байна.
12	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төрийн байгууллагуудын оролцооны талаарх санал /дэд хөтөлбөртэй байх, тухайн аймаг заавал хэрэгжүүлэх шаардлага байгаа эсэхийг тодорхойлох гэх мэт/	Хөтөлбөр хэрэгжүүлэгчид орон нутгийн төрийн байгууллагуудын оролцоо харьцангуй сайн байгаа гэсэн үнэлгээ өгч байгаа. Гэвч уг хөтөлбөр нь үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа тул бүх аймаг сумдад адилхан үр дүнтэй хэрэгжиж чадахгүй байна. Иймд тухайн аймаг, сумдад ямар чиглэлээр хөтөлбөрөөс дэмжлэг үзүүлэх боломжтойг тодорхой болгох хэрэгтэй юм. Хөтөлбөрийн орон нутгийн салбар зөвлөлийн ажил муу байгаатай холбоотойгоор энэхүү хөтөлбөр хэрэгжиж байгааг мэдэхгүй сумд маш олон байна. Мөн сумдын түвшинд мэргэжилтэй боловсон хүчин дутмаг байгаагаас зарим үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бэрхшээл тулгарсаар байна.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА